НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2022 оны 03 дугаар сарын 28 | Дугаар 30 | Улаанбаатар хот

Хамтарсан баг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2017 оны А/173, А/251, А/380 дугаар тушаалыг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн хороод тус бүрт Хамтарсан баг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Хамтарсан багийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Хамтарсан багийн үйл ажиллагааны болон санхүүжилтийн зарцуулалтын тайланг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд сар бүр ирүүлэхийг Хамтарсан багуудад үүрэг болгосугай.

ДАРГА А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн зургадугаар хуралдааны 30 дугаар тогтоолын хавсралт

Баянзүрх дүүргийн хороодын Хамтарсан багийн бүрэлдэхүүн

| | |
|---|---|
| Хамтарсан багийн ахлагч: | Хорооны засаг дарга |
| Нарийн бичгийн дарга: | Хорооны Нийгмийн ажилтан |
| Гишүүд: | Хорооны өрхийн эмч (эрүүл мэндийн Нийгмийн ажилтан) |
| | Сургуулийн Нийгмийн ажилтан |
| | Халамжийн Нийгмийн ажилтан |
| | Хорооны Цагдаагийн адба хаагч |
| Шаардлагатай бол: | Цэцэрлэгийн арга зүйч |
| | Хүүхэд гэр бүлд үйлчилгээ үзүүлдэг Төрийн бус байгууллагын төлөөлөл |